



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГАА

ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан



БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА
ХЭМЖЭЭ

11

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР,
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

4

ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ
ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

13

ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ
ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

41

| № | Арга хэмжээний нэрс | Нийт заалт | Биелэлт /хагас жил/ |
|---|------------------------------------------------------|------------|------------------------|
| 1 | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт | 69 | 81.0% |
| 2 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 0 | - |
| 3 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт | 3 | 33.3% |
| 4 | Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт | 41 | 93.6% |
| 5 | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт | 0 | - |
| 6 | Шилэн дансны хөтлөлт | 18 | 88.5 |
| 7 | Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт | 45 | 100.0% |
| | Дүн | 176 | 88.7% |

Ирсэн албан бичиг

217

Явсан албан бичиг

319

Тайлан

57

Сайдын шуурхайн биелэлт

36

Өргөдөл, гомдол

48



- Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын чуулганы 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дагаж мөрдөх бусад хуулийн хамт эцэслэн батлуулсан бөгөөд уг хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хуулийн төслийг хэлэлцэн батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт Далайн захиргааны дарга болон Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга нар орж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.



- “Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллагын тухай 1976 оны конвенц”-ын 2008 оны нэмэлт, өөрчлөлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар соёрхон батлуулсан.

- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хорооноос гаргасан асуулгын дагуу англи, монгол хэл дээр боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.



- “Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллагын тухай 1976 оны конвенц”-ын 2008 оны нэмэлт, өөрчлөлт болон ОУДБ-ын “Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай 1978 оны конвенц”-од 2010 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Төрийн мэдээлэл эмхтгэлд нийтлүүлсэн.

Хөлөг онгоцны бүртгэлт, хяналтын чиглэлээр



SINGAPORE 2003

“МХОБ ХХК”



Сингапур Улсын холбогдох байгууллагад бүртгэлийн компанийг татан буулгах талаар хүсэлт гаргаж 2021 оны 03 дугаар сараас эхлэн Монгол Улсын Далайн захиргаа бүртгэлийн үйл ажиллагааг Улаанбаатар боомтоос эрхлэн явуулж байна.



УЛААНБААТАР 2021

“ДАЛАЙН ЗАХИРГАА”



Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд

Нийт: ~4,225 Хөлөг онгоц 2022/12/30 хүртэл

GT: ~503,240 24 Гаруй орны

256 Хөлөг онгоц идэвхтэй бүртгэлд байна.

Хөлөг онгоцны бүртгэлт, хяналтын чиглэлээр



196 хөлөг онгоц шинээр бүртгэсэн
256 хөлөг онгоц идэвхтэй бүртгэлд байна

Бүртгэгдсэн онгоцны тоо 2022




**2022 ОНЫ ХӨЛӨГ
 ОНГОЦНЫ БҮРТГЭЛИЙН
 ОРЛОГО:**

| Он | Бүртгэлийн орлого /USD/ |
|------|-------------------------|
| 2020 | 111,076.44 |
| 2021 | 820,364.25 |
| 2022 | 1,279,179.38 |

Үзлэг, шалгалтын мэдээлэл

| | 2020 | 2021 | 2022 |
|------------------------------------------|------|------|------|
| Далбааны эзэн улсын үзлэг, шалгалтын тоо | 0 | 0 | 10 |




Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц дээр Далбааны эзэн улсын үзлэг, шалгалтын ажлыг дотоодын болон гадаад гэрээт хянан шалгагчдаар дамжуулан хяналт тавьж ажиллаж байна



Хөлөг онгоцны төрөл

- Ерөнхий ачаа тээврийн онгоц 82 (General Cargo)
- Газрын тос болон химийн бодис тээвэрлэгч хөлөг онгоц 35 (Oil / Chemical tanker)
- Чирэгч хөлөг онгоц 31 (Tug)

1 Зуучлагч агенттай гэрээ байгуулсан



600 гаруй ширхэг

Хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээ

113 ширхэг

Хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээний сунгалт

1595 ширхэг (900- PCOE, 695- COE)

Хөлөг онгоцны багийн гишүүдийн ур чадварын мэргэжлийн гэрчилгээг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ гаргасан байна.



Бүртгэлийн гэрчилгээ
QR кодтой болсон



Хүчинтэй эсэхийг шалгах


Цахим гэрчилгээ олгох асуудлыг судлан ажиллаж байна.

Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр



НҮБ-ын “Хуурай боомтын тухай” ЗГ хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- 2019-2022 онд хийж гүйцэтгэсэн 4 судалгааг салбарын эрдэмтэн судлаачдаар хянуулан, гарын авлага болгон хэвлүүлсэн.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвөөс 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Монгол Улсын Хуурай боомтын талаарх зөвлөлдөх уулзалт”-д “Хуурай боомтыг Монгол Улсад байгуулах хэрэгцээ, боломж, нөхцөл шаардлагын тухай” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэгт оролцсон.
- Монгол Улсын урд хил болох Замын-Үүдэд хуурай боомт байгуулах талаар төслийн баг ажиллуулах тухай хүсэлтийг ЗТХЯ-аар дамжуулан Дэлхийн банканд гаргасан.





2022 онд хийж гүйцэтгэсэн судалгааны ажлууд:

- Эрдэнэс таван толгой ТӨХК-н нүүрсийг ОХУ-ын Алс дорнодын далайн боомт болон БНАСАУ-ын Ражин боомтоор дамжуулан гуравдагч оронд тээвэрлэн хүргэх боломж, эдийн засгийн тооцоолол, судалгаа;
- БНХАУ-тай Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрт тусгагдсан боомтуудыг нүүрс, чингэлэг тээврийн төмөр замын тариф болон бусад холбогдох үзүүлэлтээр Тяньжин боомттой харьцуулсан судалгаа;
- Европын Холбооны улсуудын далайн боомтуудыг ашиглах талаарх танилцуулга, судалгаа;
- ОХУ-аас явуулж буй цэргийн ажиллагаанаас далайн тээврийн салбар, ялангуяа далайд гарцгүй Монгол улсад нөлөөлж буй сөрөг нөлөөллийн талаарх судалгаа, эрсдэлийн үнэлгээ;
- ОХУ-ын Алс дорнодын нүүрсний шинэ боомтын төсөл болох Вера, Суходол боомтуудын талаарх танилцуулга.



ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай байгуулсан санамж бичгийн хүрээнд салбарын боловсон хүчнийг чадавхжуулах зорилгоор 2021-2022 оны хичээлийн жилийн II улиралд нийт 14 оюутанд “Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа” ETR449 код бүхий 3 кредитийн хичээлийг батлагдсан хөтөлбөрийн дагуу зааж эзэмшүүлсэн.

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр



МОНГОЛ УЛСАД УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАР
ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 70 ЖИЛИЙН ОЙ

Хөвсгөл нуурт усан онгоц аялж эхэлсний 112 жил, Монгол Улсад усан замын тээврийн салбар үүсэж хөгжсөний түүхт 70 жилийн ойг 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд анх удаа албан ёсоор тэмдэглэн өнгөрүүлэхээр бэлтгэл ажлуудыг хангаж, амжилттай зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 254 дүгээр тогтоол:


- “Усан зам, далайн тээвэрчдийн өдөр”-ийг жил бүрийн 08 дугаар сарын 20-ны өдөр тэмдэглэж байхаар,
- “Усан зам, далайн салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгтэй болох асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.



Усан зам, далайн салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгийн загвар



Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр




**ЦАХИМ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
НЭГДСЭН СИСТЕМ**

www.e-mongolia.mn

Дараах үйлчилгээг *E-Mongolia системээр* дамжуулан хүлээн авч шийдвэрлэх боломжтой болсон. Үүнд:

- Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэх, улсын дугаар, гэрчилгээ олгох;
- Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх;
- Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах.




QR код ашиглан
мэдээлэл шалгана уу

Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн сангийн программ хангамжид жолооч бүртгэлийг шинээр нэмэх хөгжүүлэлтийн ажил хийгдсэн. Үүний үр дүнд усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэхийг QR кодын нууцлалтайгаар хэвлэж байна.

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр



Монгол Улсын Шадар сайдын 2019 онд баталсан “Үер уснаас үрсээ хамгаалъя” аяны удирдамжийн дагуу Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх өдөрлөг”-ийг хамтран зохион байгуулж, стандартын аврах хэрэгслийн ач холбогдол, ОУДБ-ын “Хүйтэн усанд амь насаа аврах зааварчилгаа” зэрэг иргэдийг усны ослоос урьдчилан сэргийлэх талаарх мэдээллээр хангах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр



Байгууллагын боловсон хүчнийг мэргэшүүлэх ажлын хүрээнд:

БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институттэй байгуулсан Санамж бичгийн хүрээнд Далайн захиргааны холбогдох мэргэжилтнүүдийг усан онгоц дээрх аюулгүй ажиллагаа болон техникийн хяналтын үзлэг явуулах анхан шатны сургалтад БНСУ-ын Бусан хотноо 2022 оны 06 дугаар сарын 08-17-ны өдрүүдэд хамруулж, гэрчилгээжүүлсэн.

БНСУ-д хамрагдсан сургалтын үр дүн:

- ❖ БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институтэд туслах далайчны анги нээх, хөлөг онгоцны офицер инженерээр Монгол оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцуулах асуудлыг шийдвэрлэхээр тохиролцсон.
- ❖ Холбогдох мэргэжилтнүүдийг сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон орчинд сургалтад хамруулсан бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификаттай болсон.
- ❖ Монгол Улсын дотоодын усан замын тээврийн салбарын эрх зүйн баримт бичигт хийх дүн шинжилгээг БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институтээр гүйцэтгүүлэхээр болсон.



Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр



❖ Азийн орнуудын эмэгтэйчүүдийн холбоо (WIMA ASIA)-ноос зохион байгуулагддаг ээлжит хурал;

❖ НҮБ-ын Далайн эрх зүйн конвенцын заавал дагаж мөрдөх олон улсын эрх зүйн баримт бичиг боловсруулах тавдугаар бага хурал;

❖ АНУ-ын Сандиа үндэсний лабораториос зохион байгуулсан “Хөлөг онгоцны бүртгэлийн эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалт;

❖ Олон улсын далайн хуулийн институтээс зохион байгуулсан “Далайчдын эрх” сэдэвт цахим сургалт;

❖ Олон улсын далайн хуулийн институтээс зохион байгуулсан “Далайн орчны хамгаалал, удирдлага” сэдэвт цахим сургалт;

❖ БНСВУ-ын Дананг хотноо зохион байгуулагдсан “Далбааны эзэн улсын эрх үүргийн хэрэгжилтийг сайжруулах тухай олон улсын уулзалт, семинар.

❖ БНАСАУ-д авсан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар Монгол Улсын Засгийн газартай хийх цахим зөвлөгөөн;

❖ Филиппин Улсын Эмэгтэй далайчдын холбооноос цахимаар зохион байгуулагдсан далайд гарцгүй орнуудын далайн салбарын талаарх хурал;



Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр



Далайн захиргаа болон БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт /KIMFT/ хооронд 2017 онд байгуулсан хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчилж, БНСУ-ын Далайн тээврийн аюулгүй байдлын захиргаа /KOMSA/-тай гурван талт хамтын ажиллагааг эхлүүлэх Харилцан ойлголцлын санамж бичгийг БНСУ-ын Бусан хотноо 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан.

БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт /KIMFT/ болон БНСУ-ын Далайн тээврийн аюулгүй байдлын захиргаа /KOMSA/-тай байгуулсан гурван талт хамтын ажиллагааг эхлүүлэх Харилцан ойлголцлын Санамж бичгийн хүрээнд тус институтын холбогдох төлөөлөгчдийг 2022 оны 08 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд урилгаар авчран, Монгол Улсын далайн болон усан замын тээврийн салбар дахь хамтын ажиллагааны талаар уулзалт зохион байгуулж, Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь хяналтын байрыг танилцуулан, техникийн тусламж авахаар харилцан тохиролцсон.






Далайн захиргааны 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 70 гаруй ажил хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.



Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр:

- Хуурай боомтын талаар хийсэн судалгаануудын хүрээнд ажлын хэсэгт орж ажиллан хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Монгол Улсын импортын бараа бүтээгдэхүүнийг далайн боомтоор дамжуулан тээвэрлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийг хөнгөвчлөхөд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.
- ЗТХЯ-наас өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүнийг гуравдагч оронд гаргахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Хөрш орнуудын боомтоос “Монгол-Саммок Ложистик” хамтарсан компаниар дамжуулан далайгаар гуравдагч оронд нүүрс тээвэрлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллана.






Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:



- Далай ашиглах тухай хууль батлагдсантай холбогдуулан дагалдан гарах 14 журмыг батлуулах;
- Далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагчийн эрх авах асуудлыг шийдвэрлүүлэх;
- Монгол Улсын төрийн далбаа мандуулан их далайд аялж буй хөлөг онгоцонд Далбааны эзэн улсаас хийх хяналт, үзлэг, шалгалтын ажлыг улсын байцаагч болон гэрээт хянан шалгагчдаар дамжуулан зохион байгуулна.
- Хамтран ажиллах зуучлагч байгууллагын тоог нэмж, шинээр гэрээ байгуулах;
- Олон улсын хөлөг онгоцны мэдээллийг шалгах, хянах системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, ажлын ачаалал болон бүртгэлтэй холбоотой зардлыг багасгах чиглэлээр анхаарч ажиллана.





Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:



- Архангай аймгийн Өгийнуур суманд усан замын тээврийн “Хяналтын пост”-ын байгуулах барилга бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.
- Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч тээврийн үйлчилгээнд тавигдах шаардлага бүхий стандартыг боловсруулж батлуулна.
- Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллах талаар орон нутгийн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.
- Хөвсгөл нуурын судалгаа шинжилгээ, усан замын зураглал хийх, усан замын эко зогсоол барих, судалгаа шинжилгээний зориулалттай завь оруулж ирэх хамтарсан төслийн сонгон шалгаруулалтад оролцоно.
- Усан замын тээврийн хэрэгслийн 2023 оны техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулна.
- “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинарыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулна.
- Усан замын тээврийн хяналтад тээврийн хэрэгслийн байршил тогтоох GPS тоног төхөөрөмжийг ашиглана.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГАА

Анхаарал хандуулсанд баярлалаа!

Утас: +976 7011 4802
+976 11 261489

Факс: +976 11 310642

И-мэйл: info@monmarad.gov.mn

Вэбсайт: www.monmarad.gov.mn